ЗАВХАН АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 07 сарын 10 өдөр Дугаар А/23 Улиастай

Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн ажлын албаны бүрэлдэхүүнийг шинэчлэн томилох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, Эрүүл мэндийн сайдын 2015 оны 08 дугаар сарын 05-ний өдрийн 298 дугаар тушаалыг үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн ажлын албаны бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. Эрүүл мэндийн сайдын 298 дугаар тушаалаар батлагдсан журам, ажлын албаны чиг үүргийг мөрдөж ажиллахыг ажлын албаны дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

3. Ажлын албаны хурлын үйл ажиллагааг тухай бүр журмын дагуу зохион байгуулж, тусгай зөвшөөрөл бүхий байгууллагуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган, хяналт тавьж ажиллахыг ажлын албаны дарга /Д.Бямбаа/-д үүрэг болгосугай

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан аймгийн Эрүүл мэндин газрын даргын 2018 оны 01 дүгээр сарын 18-ний өдрийн тушаалыг хүчингүй болсонд тооцсугай

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудит хариуцсан мэргэжилтэн (Ш.Лхагвасүрэн)-д даалгасугай.

ДАРГА Ч. ДЭМЧИГСҮРЭН

ИЮЕ0002

ИКОЕ0002

Эрүүл мэндийн газрын даргын
2020 оны А/28..дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт

Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа
эрхлэх тусгай зөвшөөрлийн ажлын албаны бүрэлдэхүүн

| | |
|---|---|
| Ажлын албаны дарга | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хэлтсийн дарга |
| Гишүүд | Эмийн чанар, аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн |
| | Эрүүл мэндийн эдийн засаг, хөрөнгийн бүртгэл, хөрөнгө оруулалт, төсвийн төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн |
| | Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, эрсдэл, үнэлгээ,яаралтай тусламж хариуцсан мэргэжилтэн |
| | Орчны эрүүл мэнд, эрүүл ахуй /уур амьсгалын өөрчлөлт, агаарын бохирдлыг бууруулах, ахуйн шавж, мэрэгч устгал, ариутгал, халдваргүйтгэл, эмнэлгийн хатуу ба шингэн хог хаягдал хариуцсан мэргэжилтэн |
| | Эрүүл мэндийн статистик мэдээ, мэдээлэл хариуцсан мэргэжилтэн |
| Нарийн бичгийн дарга | Хууль эрх зүй, эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрөл, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй хариуцсан мэргэжилтэн |